



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 08 сарын 06 өдөр

Дугаар 6/34

Чингис хот

Хэрлэн сумын Засаг дарга Ц.Идэрбатыг
үүрэгт ажлаас нь чөлөөлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 32 дугаар зүйлийн 32.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хэрлэн сумын Засаг дарга Цагаанхүүгийн Идэрбат нь өөрийн хүсэлтээр үүрэгт ажлаасаа чөлөөлөгдөх хүсэлт гаргасан тул 08 дугаар сарын 06-ны өдрөөс эхлэн чөлөөлсүгэй.

2. Ц.Идэрбаттай холбогдох тооцоог хийж дуусгахыг Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч /Д.Баярмаа/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 08 сарын 08 өдөр

Дугаар 5/34

Чингис хот

Чиг үүргийг хуваарилах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.1, 29.1.2, 29.1.3, 29.1.4, 29.1.5, 29.1.5-ын "а" 1.6-ийн "а", дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд дэд бүтэц, төсөв санхүү, байгаль орчин, хөдөө аж ахуйн салбарын асуудлыг аймгийн Засаг даргын орлогч Ц.Чогсомжавт, хүн амын нийгэм-соёлын үйлчилгээ, нийгмийн хамгааллын асуудлыг аймгийн Засаг даргын орлогч Г.Хэрлэнчулуунд тус тус хариуцуулан ажиллуулж чиг үүргийг хуваарилан төрийн бодлого хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулсугай.

2. Энэхүү захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч Ц.Чогсомжав, аймгийн Засаг даргын орлогч Г.Хэрлэнчулуун нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ